



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 16

Номгон

Аймгийн нөөцөд байгаа өвсний үлдэгдлийг  
акталж, шинээр татсан өвс, улаан хивэг, хорголжин  
тэжээлийн үнийг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн нөөцөд 2013 онд татсан өвсний үлдэгдэл болох 2849 боодол өвсийг акталж устгасугай.

2. Шинээр 2016 онд татсан 212,2 тонн өвс, 30 тонн улаан хивэг, 8 тонн хорголжин тэжээлийн зарж борлуулах үнийг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн нөөцөд 2013 онд татсан өвсний үлдэгдэл болох 2849 боодол өвсийг акталж устган, шинээр татсан өвс, тэжээлийн чанар, аюулгүй байдлыг хангаж, зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц. ОТГОНБАЯР

116187

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын  
18-ны өдрийн 16 дугаар тогтоолын хавсралт



ШИНЭЭР АЙМГИЙН НӨӨЦӨД ТАТСАН ӨВС,  
УЛААН ХИВЭГ, ХОРГОЛЖИН ТЭЖЭЭЛИЙН  
ЗАРЖ БОРЛУУЛАХ ҮНЭ

| №        | Бүтээгдэхүүний нэр | Тоо хэмжээ /боодол, уут/ | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Нийт үнэ   | Нийт хэмжээ /тн/ |
|----------|--------------------|--------------------------|-------------------------|------------|------------------|
| 1        | Өвс                | 10 610 боодол            | 7 400                   | 78 514 000 | 212,2 тн         |
| 2        | Улаан хивэг        | 1 200 уут                | 12 000                  | 14 400 000 | 30 тн            |
| 3        | Хорголжин          | 200 уут                  | 20 000                  | 4 000 000  | 8 тн             |
| НИЙТ ДҮН |                    |                          |                         | -          | -                |
|          |                    |                          |                         | 96 914 000 | 250,2 тн         |

Жич: Өвс 1 боодол тус бүрийг 20 кг-аар тооцов. Улаан хивэг 1 уутандаа 25 кг-аар, хорголжин тэжээл 1 уутандаа 40 кг-аар савлагдсан болно.

ооо